БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2023/75/НА-СТА-ТШЗ**


Дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган
Утас:99417382 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Женисбек
Утас: 99932710 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn
Аудитор: Ж.Назгүл
Утас: 99668909 Цахим хаяг: nazgulj@audit.gov.mn


Цахим хуудас: www.audit.mn

Баян-Өлгий аймаг

2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 17
4.1 Ерөнхий зүйл ........ 17
4.2 Материаллаг байдал ........ 17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 18
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 19
5.1 Төлбөрийн акт ........ 19
5.2 Албан шаардлага ........ 19
5.3 Зөвлөмж ........ 19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

2023.02.24 № 184

танай ____________-ны № ____________-т

НОГООННУУР СУМЫН ХҮҮХДИЙН
2 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Т.ГҮЛМАЗАТ
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ногооннуур сумын Хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Цэцэрлэгийн эрхлэгчийн 2022 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн А/26 дугаар тушаалаар жилийн эцсийн эд хөрөнгийн тооллого хийх ажлын хэсгийг томилсон боловч 20,517.5 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, үлдэгдлийг тооцоо хийж тулган баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар хөрөнгийн тооллоготой холбоотой өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан.

2. Тайлант онд байгууллагын нярвын бараа материалын тайлан гаргаагүй, нягтлан бодогч нь бараа материал, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналыг хөтлөөгүй зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.6 гэсэн заалтууд болон УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Өмч хөрөнгийн бүртгэл тооллого, төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих дотоод хяналт хангалтгүй байна.

**Аудитын гол асуудал**

Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс гаргасан цалингийн цэсээр гарт олгох цалингийн дүн болон ажилчдын дансанд шилжүүлсэн дүн зөрүүтэй байгааг аудитын явцад цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас баталгаажуулах боломжгүй байсан болно.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **27,836,090.00** | **45,931,696.53** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 25,414,194.53 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 25,414,194.53 |
| **3121** | **Төгрөг** | - | 25,414,194.53 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 25,414,194.53 |
| **33** | **АВЛАГА** | 15,000,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 15,000,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 15,000,000.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 12,836,090.00 | 20,517,502.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 12,836,090.00 | 20,517,502.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 44,290.00 | 3,892,252.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,087,000.00 | 5,046,700.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | - | - |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 700,000.00 | - |
| 35450 | Барилгын засварын материал | - | - |
| 35460 | Хүнсний материал | 3,614,800.00 | 4,131,350.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,390,000.00 | 7,447,200.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **752,384,065.15** | **744,488,447.07** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 752,384,065.15 | 744,488,447.07 |
| 391 | Газар | - | - |
| **392** | **Биет хөрөнгө** | 748,984,065.15 | 741,088,447.07 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 725,352,260.00 | 725,352,260.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (24,178,408.80) | (36,267,613.20) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 36,535,226.00 | 51,535,226.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (7,527,957.14) | (15,950,002.38) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 16,125,345.47 | 16,125,345.47 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (3,057,069.84) | (4,724,604.72) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 7,168,336.58 | 7,168,336.58 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (1,433,667.12) | (2,150,500.68) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 3,400,000.00 | 3,400,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 3,400,000.00 | 3,400,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **780,220,155.15** | **790,420,143.60** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **-** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **780,220,155.15** | **790,420,143.60** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 780,220,155.15 | 790,420,143.60 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,400,000.00 | 3,400,000.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 3,400,000.00 | 3,400,000.00 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 776,820,155.15 | 787,020,143.60 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 776,820,155.15 | 776,820,155.15 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 10,199,988.45 |

| | | | |
|---|---|---|---|
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **780,220,155.15** | **790,420,143.60** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **445,727,600.00** | **580,354,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,390,000.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,390,000.00 | - |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 5,390,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 5,390,000.00 | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **440,337,600.00** | **580,354,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 427,787,600.00 | 520,675,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 520,675,900.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 15,240,000.00 | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 412,547,600.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 205,000.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205,000.00 | 103,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 12,345,000.00 | 59,574,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,345,000.00 | 59,574,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **425,327,297.82** | **570,154,011.55** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **425,327,297.82** | **570,154,011.55** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 425,327,297.82 | 569,940,862.55 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 322,979,553.00 | 393,272,256.47 |
| 210101 | Үндсэн цалин | 277,609,200.00 | 331,437,458.22 |
| 210102 | Нэмэгдэл | - | 50,816,012.25 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | - |
| 210104 | Урамшуулал | 27,232,473.00 | 11,018,786.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 18,137,880.00 | |
| 210106 | Ажиллагчдад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,287,700.00 | 64,392,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,461,700.00 | 45,322,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,206,500.00 | 4,767,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,565,200.00 | 3,814,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 641,300.00 | 953,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,413,000.00 | 9,535,500.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | - | - |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,296,500.00 | 18,987,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,237,000.00 | 5,118,181.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,059,500.00 | 13,868,819.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 5,079,713.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 640,410.00 | |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 553,500.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 546,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,339,803.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 22,473,947.00 | 61,160,150.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 21,969,947.00 | 61,160,150.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 504,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 390,600.00 | - |
| 210701 | Гадаад албан томилолт | - | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 390,600.00 | |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 250,000.00 | 1,258,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 1,258,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,569,284.82 | 30,870,556.08 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 7,309,814.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | 665,124.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 18,569,284.82 | 22,895,618.08 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 213,149.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 213,149.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 213,149.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **20,400,302.18** | **10,199,988.45** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **20,400,302.18** | **10,199,988.45** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **425,097,600.00** | **580,354,000.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **425,097,600.00** | **580,354,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 412,547,600.00 | 520,675,900.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 520,675,900.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 412,547,600.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 205,000.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 205,000.00 | 103,500.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 12,345,000.00 | 59,574,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 12,345,000.00 | 59,574,600.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **422,377,600.00** | **554,939,805.47** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **422,377,600.00** | **554,939,805.47** |

| | | | |
|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **422,377,600.00** | **554,726,656.47** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 320,650,100.00 | 393,272,256.47 |
| 210101 | Үндсэн цалин | 277,609,200.00 | 331,437,458.22 |
| 210102 | Нэмэгдэл | | 50,816,012.25 |
| 210104 | Урамшуулал | 26,650,100.00 | 11,018,786.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 16,390,800.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 43,287,700.00 | 64,392,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,461,700.00 | 45,322,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,206,500.00 | 4,767,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,565,200.00 | 3,814,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 641,300.00 | 953,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,413,000.00 | 9,535,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,295,000.00 | 18,287,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,237,000.00 | 6,287,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 9,058,000.00 | 12,000,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,321,000.00 | 103,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 390,600.00 | 103,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,971,900.00 | 63,585,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 78,100.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 26,259,100.00 | 63,585,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 634,700.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 15,050,000.00 | 150,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,000,000.00 | |
| 210604 | Урсгал засвар | 50,000.00 | 150,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 390,600.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 390,600.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 396,500.00 | 1,258,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 146,500.00 | |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 250,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 1,258,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 14,800.00 | 13,677,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 10,677,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 14,800.00 | 3,000,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **-** | **213,149.00** |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 213,149.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 213,149.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **2,720,000.00** | **25,414,194.53** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **2,720,000.00** | **-** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **2,720,000.00** | **-** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 2,720,000.00 | - |
| 225102 | Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/ | 2,720,000.00 | |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(2,720,000.00)** | **-** |

| | | | |
|---|---|---|---|
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 25,414,194.53 |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 25,414,194.53 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 3,400,000.00 | | 776,820,155.15 | | 780,220,155.15 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,400,000.00** | **0.00** | **776,820,155.15** | **0.00** | 780,220,155.15 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | 0.00 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,400,000.00** | **0.00** | **776,820,155.15** | **0.00** | 780,220,155.15 |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,400,000.00** | **0.00** | **776,820,155.15** | **0.00** | 780,220,155.15 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,400,000.00** | **0.00** | **776,820,155.15** | **0.00** | 780,220,155.15 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 10,199,988.45 | | 10,199,988.45 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,400,000.00** | **0.00** | **787,020,143.60** | **0.00** | 790,420,143.60 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **581,583,700.00** | **554,410,007.47** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 581,583,700.00 | 554,410,007.47 |
| 210 | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 581,583,700.00 | 554,410,007.47 |
| 2101 | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 420,232,800.00 | 393,059,107.47 |

| | | | |
|---|---|---|---|
| 210101 | Үндсэн цалин | 341,436,200.00 | 341,990,987.66 |
| 210102 | Нэмэгдэл | 67,098,700.00 | 36,880,219.86 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 11,697,900.00 | 14,187,899.95 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 64,392,900.00 | 64,392,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 45,322,100.00 | 45,322,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,767,700.00 | 4,767,700.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,814,100.00 | 3,814,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 953,500.00 | 953,500.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,535,500.00 | 9,535,500.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 18,287,000.00 | 18,287,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,287,000.00 | 6,287,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,000,000.00 | 12,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 63,585,800.00 | 63,585,800.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | 63,585,800.00 | 63,585,800.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 150,000.00 | 150,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 150,000.00 | 150,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,258,000.00 | 1,258,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,258,000.00 | 1,258,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 13,677,200.00 | 13,677,200.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 10,677,200.00 | 10,677,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **581,583,700.00** | **579,824,202.00** |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 520,675,900.00 | 520,675,900.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 520,675,900.00 | 520,675,900.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 60,907,800.00 | 59,148,302.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 60,907,800.00 | 59,148,302.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 25,414,194.53 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 50 | 50 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20 | 20 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 29 | 29 |
| 620004 | Гэрээт ажилтан | | |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 150 | 150 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | - | - |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | | |
| 630002 | Хувийн ЕБС | | |

| | | | |
|---|---|---|---|
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 150 | 150 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 150 | 150 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **50** | **50** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 21 | 21 |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1 | 1 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 28 | 28 |
| 650010 | Гэрээт ажилтан | - | - |
| 650011 | Улс төрийн албан хаагч (УТ) | | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **215,000.00** | **103,500.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **215,000.00** | **103,500.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 215,000.00 | 103,500.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 215,000.00 | 103,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | 103,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 215,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 215,000.00 | 103,500.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 215,000.00 | 103,500.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 215,000.00 | 103,500.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

*Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар*

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх чиг үүрэгтэй байгууллага.

Цэцэрлэг нь 2022 онд “Бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалт, үйл ажиллагаагаар сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх” гэсэн зорилт дэвшүүлэн ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

*Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар*

Тус байгууллага нь үйл ажиллагаандаа дараах хууль журмыг ашигладаг байна. Үүнд:

- Боловсролын тухай хууль
- Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Татварын тухай хууль гэх мэт

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах *шаардлагагүй* гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

*Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар*

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, батлаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгээгүй байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.2 сая төгрөгөөр буюу 1.3 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 25,414.2 | 25,414.2 |
| Авлага | 15,000.0 | | (15,000.0) |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 12,836.1 | 20,517.5 | 7,681.4 |
| Үндсэн хөрөнгө | 752,384.1 | 744,488.4 | (7,895.7) |
| **Нийт хөрөнгө** | **780,220.2** | **790,420.1** | **10,199.9** |
| Өр төлбөр | | | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 780,220.2 | 790,420.1 | 10,199.9 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **780,220.2** | **790,420.1** | **10,199.9** |

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оноос мөнгөн хөрөнгө 25.4 сая төгрөгөөр, бараа материалын данс 7.7 сая төгрөгөөр, Засгийн газрын хувь оролцоо данс 10.2 сая төгрөгөөр өсөж, авлагын дансны үлдэгдэл 15.0 сая төгрөгөөр, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 7.9 сая төгрөгөөр буурсан байна.

Оны эцэст улсын төсвийн санхүүжилтээс 25.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй гарсан нь цалингийн зардлын төсвийн хэмнэлт байна.

Бараа материалын данс 12.8 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба төсвийн хөрөнгөөр нийт 86.0 сая төгрөгийн бараа материал худалдан авч 78.3 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зарцуулсан.

Үндсэн хөрөнгийн данс оны эхэнд 788.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба 15.0 сая төгрөгийн хөрөнгийг авлагаар барагдуулан хүлээн авч оны эцэст 803.6 сая төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй. Үндсэн хөрөнгөнд 22.8 сая төгрөгийн элэгдэл байгуулжээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 790.4 сая төгрөг болж өмнөх оны үлдэгдлээс 10.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 595.9 сая, нийт зарлагыг 595.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас зардлыг 14.3 сая төгрөгөөр бууруулж 581.6 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг орон нутгийн төсвөөс 60.9 сая төгрөгийн, улсын төсвөөс 520.7 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 520.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 60.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 520.7 сая төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 59.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 554.6 сая төгрөг буюу 95.4 хувьтай байна. Энэ нь орон нутгийн төсвөөс 1.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсантай холбоотой. Мөнгөн хөрөнгийн дансанд 25.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй ба орон нутгийн төсвөөс 0.2 сая төгрөгийг хэмнэж төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80112-нийтлэг үйлчилгээ | 60,907.8 | 59,361.3 | 1,546.5 | 97.5 |
| 2 | 81605-эрүүл мэндийг дэмжих | 1,700.0 | 1,700.0 | - | 100.0 |
| 3 | 81807-цэцэрлэгийн хүүхдийн хоол | 63,585.8 | 63,585.8 | - | 100.0 |
| 4 | 81816-хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 1,997.2 | 1,997.2 | - | 100.0 |
| 5 | 81823-боловсролын байгууллагын багш | 1,700.0 | 1,700.0 | - | 100.0 |
| 6 | 81834-боловсролын стандарт | 352,328.8 | 332,454.3 | 19,874.5 | 94.4 |
| 7 | 81835-сургалтын хэвийн үйл ажиллагаа | 99,364.1 | 93,824.4 | 5,539.7 | 94.4 |
| | **Дүн** | **581,583.7** | **554,623.0** | **26,960.7** | **95.4** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт дансаар санхүүжилт аваагүй байна. Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэг нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03 дугаартай албан бичгээр 01 дүгээр сарын 27-ны өдөр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Ногооннуур сумын хүүхдийн 2 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 425.3 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 4.2 сая төгрөгөөр тогтоосныг тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор төсвөө 27.2 сая төгрөгөөр хэмнэж ажилласан байна. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад алдаа зөрчил гараагүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээлэлд шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийсэн аудитаар эхний 9 сарыг шалгаж шилэн дансны мэдээлсэн байдлын дундаж, 21.1 хувьтай, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн ба 2022 оны үлдсэн 3 сарын мэдээллийг байршуулжээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд алдаа, зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар нийт 530.3 сая төгрөгийн зөрчил илэрч 515.6 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 14.7 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн байна.

1. Жилийн эцэст 59.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 12.8 сая төгрөгийн бараа материалын тооллогыг зохих журмаар хийгээгүй, үндсэн хөрөнгө, бараа материалын үлдэгдлийг тооцоо хийж баталгаажуулаагүй, Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын дагуу тэвчиж болох зардлын 10 хувь буюу 2.5 сая төгрөгийн хэмнэлтийг гаргаж ажиллаагүй байна.

2.Шилэн дансанд санхүүжилтийн 392.8 сая төгрөгийн 25 мэдээллийг 0 дүнтэйгээр мэдээлсэн, 11 сарын мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17.6 сая төгрөгийн зарлагын мэдээллийг огт мэдээлээгүй, 15.0 сая төгрөгийн авлага үүсгэсэн тухай шийдвэрийг мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш зарлагын 15.0 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй зэргээр нийт 440.4 сая төгрөгийн зөрчил гаргасан байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 25.0 хувьтай, 14.7 сая төгрөгийн худалдан авсан бараа материалыг шууд зардлаар бүртгэж тайлагнасан зэрэг зөрчил илэрч сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн бөгөөд биелэлт нь 14 хувьтай байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 2 | 515,625.2 | 0 | 59,800.0 | 12% |
| Зөвлөмж | 1 | 14,662.5 | 1 | 14,662.5 | 100% |
| **Нийт дүн** | **3** | **530,287.7** | **1** | **74,462.5** | **14%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Хөрөнгө, бараа материалын тооцоо, тооллого, дотоод хяналтын асуудлыг дараагийн аудитаар анхаарах шаардлагатай. Аудитаар хөрөнгийн бүртгэл тооцоо, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул гүйцэтгэлийн аудитаар дэлгэрэнгүй шалгах шаардлагатай байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

Аудитаар нийт 245.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 243.2 сая төгрөгийн зөрчил арилгуулах албан шаардлага, 2.1 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Үүнээс цэцэрлэгийн нягтлан бодогчид хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитын дүнгээр дараах зөрчилд төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Нягтлан бодогч, нярав нар цалин тогтоосон тушаалыг зөрчиж цалингийн нэмэгдэл болон сахилгын шийтгэлтэй байсан хугацааны үр дүнгийн урамшуулалд нийт 2128.6 мянган төгрөгийг төсвөөс үндэслэлгүй хууль бусаар авсан байна.

### 5.2 Албан шаардлага

Аудитын дүнгээр дараах зөрчлүүдэд албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Жилийн эцсийн хөрөнгийн тооллого хийхдээ 20.5 сая төгрөгийн бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, дүнг санхүүгийн тайлан дахь үлдэгдэлтэй тулган баталгаажуулаагүй, өмнөх оны аудитаар хөрөнгийн тооллоготой холбоотой өгсөн зөрчлийг давтан гаргасан.Нярвын бараа материалын тайланг зохих журмаар гаргаагүй, бараа материал, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй журналыг хөтлөөгүй.

2. Төрийн албан хаагчийн цалингийн нэгдсэн системээс гаргасан цалингийн цэсээр ажиллагсдын гарт олгох цалингийн дүн 302.8 сая төгрөг ба ажилчдын дансанд 332.7 сая төгрөгийн цалинг шилжүүлэн 29.8 сая төгрөгийн зөрүүтэй. Цалингаас суутгасан татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, өглөгийг үнэн зөв тайлагнаагүй.

3. Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 53.8 %-тай, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан.

### 5.3 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Бараа материалын үлдэгдлийг тоолоогүй, ажиллагсдын гарт олгох цалинд шилжүүлэх дүн зөрүүтэй. | 1 | 225,972.7 | | | 1 | 225,972.7 | | | | | | |
| Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг үндэслэлгүй илүү авсан. | 1 | 2128.6 | 1 | 2128.6 | | | | | | | | |
| Сахилгын шийтгэл ногдуулсан | 1 | 0.0 | | | | | | | 1 | 0.0 | | |
| **Дүн** | **3** | **258101.3** | 1 | 2128.6 | 1 | 225,972.7 | | | 1 | 0.0 | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийг бүрэн байршуулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 53.8%-тай | | | | | 1 | 17240.5 | | |
| **Дүн** | | | | | **1** | **17240.5** | | |
| Төрийн хэмнэлттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | **1** | **17240.5** | | |